



БАТЛАВ
САНГИЙН САЙД

Б.ЧОЙЖИЛСҮРЭН



БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

С.БЯМБАЦОГТ

ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Төв банк /Монголбанк/-ны тухай, Банкны тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай, Векселийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулиудад төлбөрийн систем, түүний оператор, оролцогч, тэдгээрийн эрх, хүлээх үүрэг, хариуцлага, цахим мөнгө, төлбөр тооцооны эцэслэлт, төлбөрийн системд Төв банкнаас тавих хяналтын талаар зохицуулаагүй тул төлбөрийн системийн өнөөгийн үйл ажиллагаа, цаашид үүсэх харилцааг зохицуулах, боловсронгуй болгох шаардлагатай байна.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай, Векселийн тухай хуулиудад төлбөр тооцоог бэлэн мөнгөөр, бэлэн бус төлбөрийн баримтаар хийхээр заасан нь төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээг хязгаарлагдмал болгож байна.

Төлбөр тооцооны үндэсний зөвлөл (ТТҮЗ)-өөс 2009 онд “Төлбөр тооцооны системийг хөгжүүлэх дунд хугацааны стратегийн баримт бичиг”-ийг баталснаар төлбөрийн системийн эрх зүйн орчинг бүрдүүлэх ажилд ахиц гарч, Төлбөрийн системийн тухай хуулийн төслийг боловсруулж эхэлсэн. Дэлхийн банкнаас Монголбанкинд 2015 оноос эхлэн үзүүлж буй техник туслалцааны хүрээнд Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг 2015-2020 онд хөгжүүлэх стратегийн баримт бичгийг боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр батлуулсан бөгөөд тус стратегийг богино хугацаанд хэрэгжүүлэх зорилгын хүрээнд төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээтэй холбоотой бүхий л харилцаа, асуудлыг цогц байдлаар зохицуулах Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн төслийг боловсруулахаар тусгасан болно.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Төлбөр хариуцагчаас төлбөрийн хэрэгслийг ашиглан төлбөрийн системээр дамжуулан төлбөр хүлээн авагчид төлбөр тооцоог гүйцэтгэх, үр дүнгийн тооцоолол хийхэд төлбөрийн системийн оператор, оролцогчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, төлбөрийн системийн үйл ажиллагаанд хяналт тавих харилцааг хуулийн төсөл нарийвчлан зохицуулна.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль батлагдсанаар “төлбөрийн систем” гэсэн ойлголтыг тодорхойлж, Монголбанк, төлбөрийн системийн оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгчдийн эрх, үүргийг тодорхойлж, төлбөр тооцооны үйл ажиллагаатай холбоотой үүсэх харилцааг зохицуулах эрх зүйн үндэслэл бүрдэнэ.

Төв банкнаас баримтлах үндэсний төлбөрийн системийн бодлогыг тодорхойлох, оролцогчдод тавигдах шаардлага, шалгуурыг тогтоох, хяналт тавих Төв банкны эрх, үүргийг хуульчилснаар төлбөрийн системийг хөгжүүлэх, шинэчлэх, зардлыг бууруулах, төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй, үр ашигтай ажиллагааг хангах боломж бүрдэнэ.

Хууль батлагдсанаар бэлэн мөнгө, төлбөрийн баримтаас гадна цахим мөнгө, төлбөрийн карт зэрэг төгрөгийг орон төлбөр тооцоонд хэрэглэгдэх төлбөрийн хэрэгслийн зөвшөөрлийг Монголбанкнаас олгох, хил дамнасан төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, хөдөлгөөнт банкны үйлчилгээ зэрэг үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөхийн зэрэгцээ зах зээлд нэвтэрч буй төлбөрийн үйлчилгээ, хэлбэрүүдийн цаашдын хөгжлийг дэмжих боломж бүрдэнэ.

Төлбөрийн системд нэвтрэх шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслийн зохицуулалт, хяналтыг Монголбанкинд төвлөрүүлснээр төлбөрийн хэрэгслүүдэд тавигдах шаардлага, нэгдмэл байдал, систем хоорондын харилцан зохицолдоо, нууцлал, аюулгүй байдал, харилцагчийн эрх ашгийн хамгаалах асуудлууд бүрэн хангагдана. Мөн төлбөр тооцоог найдвартай, тасралтгүй, түргэн шуурхай гүйцэтгэх орчинг бүрдүүлнэ.

Техник, технологийн хөгжил дэвшлийг дагаж, төлбөр гүйцэтгэх ажиллагаанд нэвтэрч байгаа цахим мөнгө, түүний шинжүүдийг олон улсын туршлагад нийцүүлэн тодорхойлж, Монголбанкны удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих эрхийг хууль ёсны болгосноор цахим мөнгөний хэрэглээний талаар үүсэж болзошгүй төөрөгдөл, мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлж болох сөрөг үр дагавраас хамгаална. Үүний үр дүнд цахим мөнгөний системүүдийн хоорондын харилцан уялдаа төдийгүй Үндэсний төлбөрийн системийн нэгдмэл байдлыг хангана.

Төгрөгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахад төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагаа чухал бөгөөд төлбөрийн системд үүсэж болох эрсдэлээс хамгаалах, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхэд Төв банк (Монголбанк)-ны зүгээс хяналт тавих эрх зүйн орчин бий болно. Ингэснээр төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгчид зөвшөөрөл олгох, шаардлагатай мэдээллийг олж авах, газар дээр нь шалгах, зайнаас хяналт тавих, аудит хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах зэрэг төлбөрийн системийн хяналтын үндсэн үйл ажиллагааг хамарсан хяналтын тогтолцоо бүрдэх юм.

Дөрөв.Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай зохицуулах үүднээс шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуультай нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй уялдуулан Төв банк /Монголбанк/-ны тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Банкны тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Зөрчлийн тухай, Векселийн тухай, Мөнгө угаах терроризмыг

санхүүжүүлэхтэй тэмцэх тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

---ooOoo---

ТАНИЛЦУУЛГА

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсад төлбөр тооцоог сүүлийн үеийн технологи ашиглан хийх болсон ч бэлэн, бэлэн бус болон цахим төлбөрийн хэрэгслийн хамгаалалтын түвшин харилцан адилгүй байна. Тухайлбал, дебит болон кредит шилжүүлэг, төлбөрийн карт зэрэг төлбөрийн цахим хэрэгслүүд болон урьдчилсан төлбөрт карт, мобайлаар хийж буй төлбөр тооцоог бэлэн төлбөрийн хэрэгсэлтэй харьцуулахад харьцангуй сул хамгаалж байна.

Төлбөрийн системийн гол асуудал болох төлбөрийн эцэслэлт, үл буцаагдах байдал, төлбөр тооцооны системийн барьцаа хөрөнгө, олон талт үр дүнгийн тооцоолол зэргийг журмаар зохицуулж байгаагаас маргаан үүссэн үед Дампуурлын тухай хууль зэрэг бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх байдал давтагдсаар байна.

Түүнчлэн төлбөрийн үйлчилгээний болон төлбөрийн хэрэгслийн харилцааны оролцогч болох төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч (тухайлбал, банк), түүний нэрийн өмнөөс төлбөрийн үйлчилгээг үзүүлж буй гэрээт төлөөлөгч (агент) болон хэрэглэгчийн эрх, үүрэг одоо болтол тодорхойгүй байгаагийн зэрэгцээ төлбөрийн систем, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн хэрэгсэл гаргагчид хяналт тавих Монголбанкны бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэх механизмыг хүчин төгөлдөр үйлчилж буй банкны салбарын хууль тогтоомжид тусгаагүй байна.

Дээр дурдсан шаардлагыг үндэслэж Үндэсний төлбөрийн системийн ил тод байдлыг дэмжих, систем хоорондын харилцан зохицолдоог хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн өрсөлдөөнт орчинг бий болгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, түүнийг олон нийтэд ойртуулах замаар Үндэсний төлбөрийн системийн тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай байдлыг хангахад чиглэсэн төлбөрийн үйлчилгээний эрх зүйн орчинг бүрдүүлэхээр Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төсөл нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийн үйл ажиллагааг бүхэлд нь зохицуулах бөгөөд бүтцийн хувьд нийт 11 бүлэг, 49 зүйлтэй.

Хуулийн төслөөр Үндэсний төлбөрийн системийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нэр томъёог холбогдох олон улсын стандарт, Монгол Улсын бусад хууль тогтоомжид нийцүүлэн тодорхойлсоноос гадна Монголбанкны Үндэсний төлбөрийн системд оролцох оролцооны эрх зүйн үндсийг тогтоож, түүний мэдээлэл авах, хяналт тавих бүрэн эрхийг тусгалаа.

Түүнчлэн Үндэсний төлбөрийн системийн үйл ажиллагааны болон техникийн стандартыг тогтоох, төлбөрийн болон үнэт цаасны клиринг, төлбөр тооцоо,

төлбөрийн үйлчилгээнд нөлөөлж болзошгүй бусад асуудлыг зохицуулах, хянах талаар зөвлөмж гаргах бүрэн эрх бүхий Зөвлөлийг байгуулж, бүтэц, дүрмийг нь Монголбанкны Ерөнхийлөгч тогтоож байхаар тусгав.

Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, төлбөрийн хэрэгсэл гаргах, систем ажиллуулах үйл ажиллагааг зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх асуудлыг төсөлд тусгасан бөгөөд үүнтэй холбогдуулан дээрх зөвшөөрөл хүссэн этгээдэд тавих шаардлага, зөвшөөрөл олгох журмыг мөн хуульчлахыг зорьлоо.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль батлагдсанаар:

1.Төв банк, төлбөрийн системийн оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгчдийн эрх, үүргийг тодорхойлж, төлбөр тооцооны үйл ажиллагаатай холбоотой үүсэх харилцааг зохицуулах эрх зүйн үндэслэл бүрдэнэ.

2.Үндэсний төлбөрийн системийн бодлогыг тодорхойлох, оролцогчдод тавих шаардлага, шалгуурыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих Төв банкны эрх, үүргийг тодорхойлсноор төлбөрийн системийг хөгжүүлэх, шинэчлэх, зардлыг бууруулах нөхцөл бүрдэхээс гадна төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй, үр ашигтай ажиллагааг хангах боломж бүрдэнэ.

3.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай, Векселийн тухай хуулиар төлбөр тооцоог бэлэн болон бэлэн бус төлбөрийн баримтаар хийхээр зохицуулсныг өргөтгөж, цахим мөнгө, төлбөрийн карт зэрэг төгрөгийг орлох төлбөр тооцооны хэрэгслээр гүйцэтгэх нөхцөлийг хангаж, цаашид зах зээлд нэвтрэх шинэ үйлчилгээ, хэрэгслийн хөгжлийг дэмжих нөхцөл бүрдэнэ.

4.Төлбөрийн системд нэвтрэх шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслийн зохицуулалт, хяналтыг Монголбанкинд төвлөрүүлснээр төлбөрийн хэрэгслүүдэд тавигдах шаардлага, нэгдмэл байдал, систем хоорондын харилцан зохицолдоо, нууцлал, аюулгүй байдал, харилцагчийн эрх ашгийн хамгаалах асуудлууд хангагдана.

5.Төлбөрийн системийн суурь зарчмыг тодорхойлж, төлбөр тооцоог найдвартай, тасралтгүй, түргэн шуурхай гүйцэтгэх эрх зүйн орчин бүрдэнэ. Төлбөр тооцоог үнэн зөв, түргэн шуурхай гүйцэтгэх, төлбөр тооцооны эцэслэлт, үл буцаагдах байдал зэрэг зарчмыг хуульчилснаар төлбөр тооцоо гүйцэтгэхэд үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах, төлбөрийн системийн хэрэглэгчдийн итгэлийг нэмэгдүүлэх, бэлэн мөнгөний хэрэглээг багасгах, зардлыг хэмнэх улмаар бэлэн бус төлбөр тооцоог дэмжих нөхцөл бүрдэнэ.

6.Техник, технологийн хөгжил дэвшлийг дагаж, төлбөр гүйцэтгэх ажиллагаанд нэвтэрч байгаа цахим мөнгийг олон улсын стандартад нийцүүлэн тодорхойлж, Монголбанкны зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих бүрэн эрхийг хуульчилснаар цахим мөнгөний хэрэглээний талаар үүсэж болзошгүй төөрөгдөл,

мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлж болох сөрөг үр дагавраас хамгаална. Үүний үр дүнд цахим мөнгөний системүүдийн хоорондын харилцан уялдаа төдийгүй Үндэсний төлбөрийн системийн нэгдмэл байдлыг хангана.

7.Төгрөгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахад төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагаа чухал бөгөөд төлбөрийн системд үүсэж болох эрсдэлээс хамгаалах, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхэд Монголбанкны зүгээс хяналт тавих эрх зүйн орчин бий болно. Ингэснээр төлбөрийн системийн хяналтын үндсэн үйл ажиллагааг хамарсан хяналтын тогтолцоог бий болгох боломж бүрдэх юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР